



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК-ИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/47/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 261885 Цахим хаяг: enkhdalaie@audit.gov.mn
Ахлах аудитор: П.Чанцалдулам
Утас: 261740 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн : Аккаунт траст аудит ХХК
Захирал П.Наранцэцэг
Цахим хаяг: acctrust.audit@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	10
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	10
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	10
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	10
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	11
4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	13
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
5.1 Шилэн дансны мэдээлэл	14
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	14
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
8. Аудитын илрүүлэлт	15
8.1 Залруулсан алдаа	15
8.2 Албан шаардлага	15
8.3 Зөвлөмж	15
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 07/574
танай _____-ны № _____-т

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Х.АЛТАЙ ТАНАА

Хараат бус аудиторын тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл 5,520.9 сая төгрөг болж төлөвлөснөөс 2,782.1 сая төгрөг буюу 101.5 хувиар давсан нь тайлант онд үнэт цаасны арилжааны дүн өмнөх онуудаас огцом өсч 1.4 их наяд төгрөгт хүрсэн, бүтээгдэхүүний нэр төрөл 9-р нэмэгдсэн зэрэг компанийн үйл ажиллагааны өсөлт, банкны хадгаламжийн хүү буурснаар хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх иргэдийн сонирхол нэмэгдсэн зэрэгтэй холбоотой байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор үйл ажиллагааны орлогыг 2,738.8 сая, зардлыг 2,719.7 сая төгрөг байхаар баталсан бөгөөд гүйцэтгэлээр 5,520.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,168.2 сая төгрөгийн зардал гарч 3,352.7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2022\0315 Auditin 2 Газар - 55.Docx

001050920

Орлого төлөвлөгөөнөөс 2,782.1 сая төгрөг буюу 101.6 хувиар давж биелсэн байна.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн тайланд 3 зорилтын хүрээнд 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Бусад мэдээлэл нь байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл тухайлбал, биржийн голлох үзүүлэлтийн өөрчлөлт, зах зээлийн үнэлгээ, үнэт цаасны арилжаа, Top 20 индекс, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, үнэт цаасны данстай иргэдийн тоо, өдөрт арилжаанд оролцогчдын тоо, хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа гэх мэт санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	554,589,808.41	2,729,363,635.92
1.1.2	Дансны авлага	84,130,892.90	97,240,920.31
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	18,336.58
1.1.6	Бараа материал	24,945,190.03	26,570,837.69
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	8,921,754.47	7,666,370.89
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	13,160,000.00	13,160,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	685,747,645.80	2,874,020,101.40
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,210,709,148.46	2,121,771,489.56
1.2.2	Биет бус хөрөнгө	561,871,087.08	382,782,168.52
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,772,580,235.54	2,504,553,658.08
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,458,327,881.34	5,378,573,759.48
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	2,193,451,446.28	926,821,279.76
2.1.1.1	Дансны өглөг	2,122,930,190.07	720,558,353.30
2.1.1.3	Татварын өр	9,541,742.21	206,262,926.45
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	11,921,103.77	14,247,509.45
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	60,979,514.00	
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,205,372,550.05	941,068,789.20
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,205,372,550.05	941,068,789.20
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - Төрийн	23,130,593,600.00	23,130,593,600.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	12,362,216.67	12,362,216.67
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	446,321,902.02	446,321,902.02
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(22,336,322,387.40)	(19,151,772,748.41)
2.3.9.1	Хуримтлагдсан ашиг/ өмнөх үеийн /	(21,298,527,848.23)	(22,336,322,387.40)
2.3.9.2	Хуримтлагдсан ашиг /тайлант үеийн /	(1,037,794,539.17)	3,184,549,638.99
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,252,955,331.29	4,437,504,970.28
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	3,458,327,881.34	5,378,573,759.48

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,100,104,609.43	5,483,078,582.38
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)	1,100,104,609.43	5,483,078,582.38
4	Хүүгийн орлого	20,003,103.96	19,301,917.80
5	Бусад орлого	4,559,025.45	18,545,780.17
6	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
7	Ерөнхий ба удирдлагын зардал	2,088,545,238.55	2,136,265,973.93
8	Бусад зардал	12,682,920.88	30,363,052.75
9	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(59,244,602.02)	57,525.19
10	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	(1,619,200.00)
11	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(1,035,806,022.60)	3,352,735,578.87
12	Орлогын татварын зардал	1,988,516.57	168,185,939.88
13	Татварын дараах ашиг (алдагдал)	(1,037,794,539.17)	3,184,549,638.99
14	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(1,037,794,539.17)	3,184,549,638.99
15	Орлогын нийт дүн	(1,037,794,539.17)	3,184,549,638.99

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	23,130,593,600.00	12,362,216.67	446,321,902.02	(21,406,988,979.67)	2,182,288,739.02
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	108,461,131.44	108,461,131.44
Залруулсан үлдэгдэл	23,130,593,600.00	12,362,216.67	446,321,902.02	(21,298,527,848.23)	2,290,749,870.46
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(1,037,794,539.17)	(1,037,794,539.17)
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	23,130,593,600.00	12,362,216.67	446,321,902.02	(22,336,322,387.40)	1,252,955,331.29
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	23,130,593,600.00	12,362,216.67	446,321,902.02	(22,336,322,387.40)	1,252,955,331.29
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	3,184,549,638.99	3,184,549,638.99
2021 оны 12-р сарын 31-рх үлдэгдэл	23,130,593,600.00	12,362,216.67	446,321,902.02	(19,151,772,748.41)	4,437,504,970.28

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,194,532,385.39	5,699,769,998.43
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,021,521,426.51	4,951,952,451.43
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	4,660,101.23	10,896,176.00
	Бусад мөнгөн орлого	168,350,857.65	736,921,371.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,263,061,226.88	3,427,313,725.08
	Ажиллагчдад төлсөн	611,476,433.08	585,159,426.87
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	181,230,650.38	182,327,806.06
	Бараа материал худалдан авахад төлсөн	22,173,545.00	23,291,525.19
	Ашиглалтын зардалд төлсөн	44,480,193.75	46,951,542.21
	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	5,564,500.00	8,120,710.00
	Татварын байгууллагад төлсөн	162,774,258.68	348,440,826.15
	Даатгалын төлбөрт төлсөн		-
	Бусад мөнгөн зарлага	235,361,646.00	2,233,021,888.60
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(68,528,841.50)	2,272,456,273.35
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,116,938.36	19,301,917.80
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	1,000,000.00	-
	Хүлээн авсан хүүгийн орлого	116,938.36	19,301,917.80
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	331,428,503.50	116,984,363.64
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	331,428,503.50	116,984,363.64
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(330,311,565.14)	(97,682,445.84)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-	-
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү	-	-
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(398,840,406.64)	2,174,773,827.51
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	953,430,215.05	554,589,808.41
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	554,589,808.41	2,729,363,635.92

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган

төгрөгөөр/

д/ д	Үзүүлэлтүүд	2020 оны гүйцэтгэл*	2021 оны			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
А	Б	1	2	3	4=3-2	5=3/2
1	Үйл ажиллагааны нийт орлого:	1,124,666.7	2,738,832.6	5,520,926.3	2,782,093.6	201.6
1.1	Арилжааны шимтгэл	400,060.6	1,126,550.6	3,548,107.2	2,421,556.5	315.0
1.2	Жилийн хураамж, үйлчилгээний хөлс	487,951.7	807,196.9	1,181,472.4	374,275.5	146.4
1.3	МІТ ашиглалтын орлого	-	504,022.5	509,974.5	5,952.0	101.2
1.4	Бусад	236,654.5	301,062.6	281,372.2	(19,690.3)	93.5
2	Үйл ажиллагааны нийт зардал:	2,101,228.2	2,719,701.7	2,168,248.2	(551,453.5)	79.7
2.1	Үйл ажиллагааны зардал	991,933.5	1,225,481.6	990,938.4	(234,543.2)	80.9
2.2	ҮХ элэгдлийн зардал	266,067.2	316,268.7	239,014.4	(77,254.3)	75.6
2.3	МІТ ашиглалтын зардал	843,227.5	1,177,951.4	938,295.4	(239,655.9)	79.7
3	Үйл ажиллагааны цэвэр орлого	(976,561.4)	19,131.0	3,352,678.1	3,333,547.1	17,524.9
4	Гадаад валютын ханшийн бодит бус цэвэр олз/гарз	(59,244.6)	-	57.5	57.5	
5	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(1,035,806.0)	19,131.0	3,352,735.6	3,333,604.6	17,525.2
6	Орлогын татвар	1,988.5	-	168,185.9	168,185.9	
7	Татварын дараах цэвэр ашиг /алдагдал/	(1,037,794.5)	19,131.0	3,184,549.6	3,165,418.7	16,646.1
8	Нийт авлага /цэвэр/	84,130.9	56,906.0	97,240.9	40,334.9	170.9
9	Нийт өглөг /МІТ төслийн зардал оруулж тооцсоноор/	2,193,451.4	772,900.0	926,821.3	153,921.3	119.9
10	Ажиллагсдын тоо	53	55	53	(2.0)	96.4
11	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох үйл ажиллагааны зардал	2	1	0.4	(0.6)	39.4
12	Хөрөнгө оруулалт	147,764.60	176,334.61	166,540.42	(9,794.2)	94.4

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдэд биет үзлэг шалгалт хийн, цаашид ашиглагдах жилийг нь тодорхойлон, дахин үнэлж бодит үнэ цэнээр бүртгэж тайлагнах, авлага барагдуулах, Сэлэнгэ аймаг, Баруунбүрэн суманд байрлах үр тарианы зориулалттай газар эзэмших эрхийг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлэхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 10-аас 03 дугаар сарын 11-ний хооронд Аккаунт траст аудит ХХК-ийн аудитор Б.Эрдэнэчимэг, туслах аудитор П.Саранчимэг нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Д.Цэцэгсүрэн, захирал П.Наранцэцэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан, зорилтод түвшний гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 1/68 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа гүйцэтгэх захирлын 2021 оны 12 дугаар сарын 23-ны А/20 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

ТУЗ-ийн дотоод аудит 2021 онд тус компанийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүү байдлын тайлангийн нийт хөрөнгийн 3,458.3 сая төгрөгөөс 1 хувиар буюу 34.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тайлант онд нийт хөрөнгийн дүн өмнөх оноос материаллаг хэмжээгээр өөрчлөгдөн 5,378.6 сая төгрөг болж, 55.5 хувиар буюу 1,920.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Иймд гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн дүн 5,378.6 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 53.8 сая төгрөгөөр тооцлоо.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн эрхэм зорилго нь үндэсний үйлдвэрлэл үйлчилгээг сэргээн хөгжүүлэх, дотоод гадаадын хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх, дэмжин урамшуулахад үйл ажиллагаагаа чиглүүлж, үнэт цаасны зах зээлийг сонгодог утгаар нь төлөвшүүлэн хөгжүүлэхэд оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг үнэт цаасны арилжаа эрхлэх, брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхийн компанийг гишүүнээр элсүүлэх, гишүүнийг түдгэлзүүлэх, гишүүнээс хасах үйл ажиллагаа байх бөгөөд олон нийтэд үнэт цаасны зах зээлийн талаар анхан шатны мэдлэг олгох зорилгоор сургалт зохион байгуулж болно гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчит хувьцаат компани статустай байна. Өмчийг 100 хувь төр эзэмших бөгөөд хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь Засгийн газраас эрх олгосон этгээд буюу Сангийн яам байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Монголын хөрөнгийн бирж ТӨХК нь Монгол Улсын Засгийн газрын 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 22 дугаар тогтоолоор байгуулагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлагыг ТУЗ, ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Сангийн сайд томилж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2.1-д “төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эрх барих дээд байгууллагын хуралд төрийг төлөөлөх этгээдийг уг хурлаар хэлэлцэх асуудал бүрээр өгөх саналын удирдамжийн хамт төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд томилох;” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг дундажаар 0.5 сая төгрөгөөр тогтоосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 21 дүгээр

зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалтай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна.

Уг ажлын хүрээнд 2002-2006 онд дуудлага худалдаагаар худалдагдаж, тухайн үед Төрийн өмчийн хорооны тогтоолоор байгууллагын балансаас хассан 3 авто тээврийн хэрэгслийн бүртгэлийг Авто тээврийн үндэсний төвийн тээврийн улсын бүртгэл, татварын албаны бүртгэлд өөрчлөлт хийлгээгүйгээс тус компанийн нэр дээр үүссэн нийт 1.1 сая төгрөгийн албан татвар, төлбөрийн нэхэмжлэлийг барагдуулж, Автотээврийн Үндэсний Төвийн мэдээллийн санд өөрчлөлт хийлгэсэн байна.

Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.3-т заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчлөөгүй ч орон тоог нэмэгдүүлээгүй, чөлөө авсан болон гарсан ажилтнуудын ажлыг хавсран гүйцэтгүүлж, цалингийн зардлыг 10.5 хувь, нийт үйл ажиллагааны зардлыг 20.2 хувиар хэмнэж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2020 оны 144 дүгээр тушаалын 2-р хавсралт "Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам", 3-р хавсралт "Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах, нягтлан бодох бүртгэлд бүртгэх аргачлал"

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	554,589.8	2,729,363.6	2,174,773.8
Авлага	84,130.9	97,259.3	13,128.4
Урьдчилж төлсөн зардал тооцоо	8,921.8	7,666.4	(1,255.4)
Бараа материал	24,945.2	26,570.8	1,625.6
Бусад эргэлтийн хөрөнгө	13,160.0	13,160.0	-
Үндсэн хөрөнгө	2,210,709.1	2,121,771.5	(88,937.6)
Биет бус хөрөнгө	561,871.1	382,782.2	(179,088.9)
Нийт хөрөнгийн дүн	3,458,327.9	5,378,573.8	1,920,245.9
Богино хугацаат өглөг	2,205,372.6	941,068.8	(1,264,303.8)
Эздийн өмч	1,252,955.3	4,437,505.0	3,184,549.7
Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн	3,458,327.9	5,378,573.8	1,920,245.9

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэл 0.6 сая төгрөг байна.

Банк дахь мөнгөний үлдэгдэлд худалдаа хөгжлийн банк дахь 2 харилцах дансны үлдэгдэл 1.0 сая, голомт банк дахь 3 харилцах дансны үлдэгдэл 1,609.0 сая, төрийн банк дахь 1 харилцах дансны үлдэгдэл 1,118.7 сая, нийт 2,729.4 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд 95 харилцагчийн 329.1 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байгаагийн 13.1 сая төгрөгийн авлага нь тайлант онд шинээр үүссэн байна. Өмнөх онуудад нийт 250.2 сая төгрөгийн найдваргүй авлагын хасагдуулга хийснээс тайлант онд 18.4 сая төгрөгийн найдваргүй авлага төлөгдөж, үлдэгдэл 231.8 сая төгрөг болсон байна. Найдваргүй авлагын хасагдуулга хийсэн нийт цэвэр авлагын 97.3 сая төгрөгийн 86.5 хувь буюу 84.2 сая төгрөг нь нэг жилээс дээш жилийн насжилттай байна.

Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 7.7 сая төгрөг болж өмнөх оноос 1.2 сая төгрөгөөр буурсан. Тус дансны үлдэгдэлд дараах зардлууд байна. Үүнд:

1. Ногдол ашгийн урьдчилгаа төлбөр 1.8 сая төгрөг нь Төрийн Өмчийн Хорооны/хуучнаар/ 2014 оны 08 дугаар 08-ны өдрийн 1а/2168 тоотыг үндэслэн 2014 оны 08 дугаар сарын 15-ны өдөр шилжүүлсэн төлбөр бөгөөд компанийн хувьцаа эзэмшигчээс ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн үед хаагдана;
2. SSL нууцлалтын сертификат 1.5 сая төгрөг 2022 оны 01-09 сарын IPO.MSE.MN веб сайтын нууцлалыг хамгаалах сертификатын төлбөр /Comodo.SSL/;
3. Тэмдэгтийн хураамж 2.2 сая төгрөг Шүүхийн шийдвэрээр хаагдах төлбөр;
4. Моннис моторс ХХК 1.7 сая төгрөг нь тээврийн хэрэгслийн сэлбэг захиалгын урьдчилгаа төлбөр бөгөөд ковидын улмаас хил, гааль хаагдсанаас шалтгаалан сэлбэгийн нийлүүлэлт хойшлогдсон;
5. Шатахуун, хэвлэл захиалга болон бусад төлбөрийн урьдчилгаа 0.5 сая төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 26.6 сая төгрөг болж 1.6 сая төгрөгөөр өссөн нь бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн худалдан авалтаас голлон нөлөөлжээ.

Бусад эргэлтийн хөрөнгө дансанд 13.2 сая төгрөгийн газар эзэмших эрх бүртгэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,121.8 сая төгрөг болж 88.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардлаас голлон шалтгаалсан байна. Тайлант онд нийт 7.7 сая төгрөгийн компьютер, дагалдах хэрэгсэл худалдан авсан байна.

Биет бус хөрөнгө дансны өөрчлөлт нь Oracle өгөгдлийн сангийн лицензийн сунгалт 109.2 сая төгрөгөөр нэмэгдсэн ба тайлант хугацааны элэгдлийн зардлаас голлон шалтгаалж буурсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 720.6 сая төгрөгийн дансны, 206.3 сая төгрөгийн татварын, нийт 926.8 сая төгрөгийн өр төлбөр байна. Дансны өглөгийн 96.6 хувийг Лондонгийн хөрөнгийн биржид төлөх 696.5 сая төгрөгийн өглөг эзэлж байна.

Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэлд 14.2 сая төгрөг байгаа бөгөөд энэ нь 2022 онд хамаарах үйлчилгээний хураамж, шимтгэл, мэдээлэл нийлүүлэх үйлчилгээний орлого болон сургалтын төлбөр байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу ерөнхий удирдлагын зардал, борлуулалт маркетингийн зардал, бусад зардал гэж ангилсан байна.

Зардлыг өмнөх онтой харьцуулахад ерөнхий удирдлагын зардал 47.7 сая, бусад зардал 17.7 сая, нийт 65.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь интернетийн зардал 10.4 хувь, шуудан холбооны зардал 10.7 хувь, шатахуун тээврийн хэрэгслийн зардал 17.6 хувь, ашиглалтын зардал 9.2 хувь, урсгал засвар 3 дахин, нийгэм соёлын арга хэмжээний зардал 2.2 дахин, маркетинг, бизнес харилцааны зардал 2.1 дахин өссөнтэй холбоотой байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Монголын хөрөнгийн бирж ТӨХК нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 2,738.8 сая төгрөгөөр, нийт зардлыг 2,719.7 сая төгрөгөөр, 19.1 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 176.3 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 5,520.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,168.2 сая төгрөгийг зарцуулж, 3,352.7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 5,520.9 сая төгрөг болж төлөвлөснөөс 2,782.1 сая төгрөг буюу 101.6 хувиар давсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 2,168.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 551.5 сая төгрөг буюу 20.3 хувийн дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь интернет ашиглалтаас бусад бүх зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Тайлант онд цэвэр ашиг 3,184.5 сая төгрөг болж, төлөвлөснөөс 3,165.4 сая төгрөгөөр илүү байгаа нь тайлант онд үнэт цаасны арилжааны дүн өмнөх онуудаас огцом өсч 1.4 их наяд төгрөгт хүрсэн, бүтээгдэхүүний нэр төрөл 9-р нэмэгдсэн зэрэг компанийн үйл

ажиллагааны өсөлт, банкны хадгаламжийн хүү буурснаар хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх иргэдийн сонирхол нэмэгдсэн зэрэгтэй холбоотой байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Монголын хөрөнгийн бирж ТӨХК нь тайлант онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулах нийт 7,930.5 сая төгрөгийн 171 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 76.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 59.7 сая төгрөгийг залруулж, 1.1 сая төгрөгийн зөрчлийг арилгасан ба 15.5 сая төгрөгийн алдаа, зөрчлийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1.6 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгснийг 100.0 хувь хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	2	1.6	2	1.6			100.0
Нийт дүн	2	1.6	2	1.6			100.0

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татах асуудал гараагүй.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 85.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 32.9 сая төгрөгийн алдаа залруулж, 38.5 сая төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага, 14.5 сая төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 53.0 сая төгрөгийн алдаа зөрчил нь шинэчлэн тогтоосон 53.8 сая төгрөгийн түвшинээс 0.8 сая төгрөгөөр бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 32.9 сая төгрөгийн 4 алдааг залрууллаа. Үүнд:

- Дэлгэрэнгүй орлогын тайлангийн өмнөх үеийн бусад орлогын дүн 3.0 сая, тайлант үеийнх 0.07 сая, нийт 3.1 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулсан.
- Тайлант онд газар эзэмших эрхэд 0.9 сая төгрөгийн элэгдэл байгуулж, зардал нэмэгдүүлснийг залруулсан.
- Оршин суугч бус этгээдээс суутгасан нэмэгдсэн өртгийн албан татварын 28.6 сая төгрөгийн өглөгийг буруу ангилж, бусад өглөгөөр тайлагнасныг татварын өглөгийн ангилалд залруулан тайлагнасан.
- Сэлэнгэ аймаг, Баруунбүрэн сум, 3-р хороонд байрлах үр тарианы зориулалттай 2 газар эзэмших эрхийн жилийн төлбөр 0.3 сая төгрөгийг капиталжуулж, хөрөнгийн өртгийг нэмэгдүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 4.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө”, 4.1.1.-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт” болон НББОУС 38 Биет бус хөрөнгийн өртгийг нэмэгдүүлэх шалгуурыг хангаагүй тул залруулав.

8.2 Албан шаардлага

Жилийн санхүүгийн тайлан дахь авлага, өглөгөөс 29 харилцагчийн 38.3 сая төгрөгийн авлага, 2 харилцагчийн 0.2 сая төгрөгийн өглөг, нийт 38.5 сая төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, нийт цэвэр авлагын 86.5 хувь нь нэг жилээс дээш насжилттай байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “...төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д “... дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээ гарахаас нь өмнө хянан баталгаажуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8 “өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Албан шаардлага:

Авлага барагдуулах арга хэмжээ авах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө харилцагчидтай үүссэн өр, авлагыг тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж байх.

8.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Газар эзэмших эрхтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

МХБ ТӨХК нь Сэлэнгэ аймаг, Баруунбүрэн сум, 3-р хороонд байрлах Аж ахуйн нэгж байгууллагын газар эзэмших эрхийн 000315235 тоот гэрчилгээтэй 149.7 га, 000315236 тоот гэрчилгээтэй 100 га үр тарианы зориулалттай газрыг тус тус эзэмшиж байна. Энэхүү хөрөнгийн эзэмшил, бүртгэлтэй холбоотой дараах зөрчлүүд байна. Үүнд:

1. Хөрөнгийг буруу ангилж, эргэлтийн хөрөнгөөр бүртгэсэн нь Сангийн сайдын 2017 оны 361 дугаар тушаалаар баталсан "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар, СТОУС-ын үнэн зөв байх батламж мэдэгдлийн шаардлага хангаагүй.
2. Үр тарианы зориулалттай газар нь хөрөнгийн биржийн эрхлэх үйл ажиллагаанд хамаарахгүй, зориулалт бус хөрөнгө бөгөөд жил бүр тус газартай холбогдох төлбөр, хураамжийн зардал гаргаж байгаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн "47.5-д.Хөрөнгийн бирж энэ хуулийн 47.1, 47.4-т зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно" заалттай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийг биет бус хөрөнгөөр ангилан бүртгэх, холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэр гаргуулж, зах зээлийн ханшаар худалдан борлуулах.

2. Биет бус хөрөнгөтэй холбоотой

Илрүүлэлт:

Өмнөх онуудад газар эзэмших эрхэд 1.3 сая төгрөгийн элэгдэл байгуулж хуримтлуулан бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;" гэсэнтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд нийтлэгээр мөрдөгдөж байгаа, журам, стандартад нийцүүлэн газар эзэмших эрхэд байгуулсан хуримтлагдсан элэгдлийг бууруулан өмнөх үеийн үр дүн рүү залруулан бүртгэх .

3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 938.9 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 264.7 сая төгрөгийн тавилга эд хогшил, 8,284.5 сая төгрөгийн программ хангамж, нийт 249 нэр төрлийн 9,488.2 сая төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох талаар холбогдох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс										
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж		
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	Монголын хөрөнгийн бирж ТӨХК	АХГ-2022/47/НА-СТА-ТӨА	Дэлгэрэнгүй орлогын тайлангийн өмнөх үеийн бусад орлогын дүн 2,999.9 мянга, тайлант үеийнх 71.0 мянга, нийт 3,070.9 сая төгрөгөөр зөрүүтэй.	Санхүүгийн тайланд залруулах	1	3,070.9	1	3,070.9									
2	Монголын хөрөнгийн бирж ТӨХК	АХГ-2022/47/НА-СТА-ТӨА	Тайлант онд газар эзэмших эрхэд 890.7 мянган төгрөгийн элэгдэл байгуулж, зардал нэмэгдүүлсэн байна.	Санхүүгийн тайланд залруулах	1	890.7	1	890.7									
3	Монголын хөрөнгийн бирж ТӨХК	АХГ-2022/47/НА-СТА-ТӨА	Оршин суугч бус этгээдээс суутгасан нэмэгдсэн өртгийн албан татварын 28,630.4 мянган төгрөгийн өглөгийг буруу ангилж, бусад өглөгөөр тайлагнасан.	Татварын ангилалд залруулан тайлагнах	1	28,630.4	1	28,630.4									
4	Монголын хөрөнгийн бирж ТӨХК	АХГ-2022/47/НА-СТА-ТӨА	Үр тарианы зориулалттай 2 газар эзэмших эрхийн жилийн төлбөр 332.0 мянган төгрөгийг капиталжуулж, хөрөнгийн өртгийг нэмэгдүүлсэн.	Санхүүгийн тайланд залруулах	1	332.0	1	332.0									
5	Монголын хөрөнгийн бирж ТӨХК	АХГ-2022/47/НА-СТА-ТӨА	Жилийн санхүүгийн тайлан дахь авлага, өглөгөөс 29 харилцагчийн 38,267.9 мянган төгрөгийн авлага, 2 харилцагчийн тооцоо 226.5 мянган төгрөгийн өглөг, нийт 38,494.4 мянган төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлж	Авлага барагдуулах арга хэмжээ авах, өр, авлагыг тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж байх	1	38494.4					1	38494.4					

			баталгаажуулаагүй байна.													
6	Монголын хөрөнгийн бирж ТӨХК	АХГ-2022/47/НА-СТА-ТӨА	<p>Үр тарианы зориулалттай 249.7 га талбай бүхий 2 газар эзэмших эрхийн эзэмшил, бүртгэлтэй холбоотой дараах зөрчлүүд байна. Үүнд:</p> <p>1.Хөрөнгийг буруу ангилж, эргэлтийн хөрөнгөөр бүртгэсэн</p> <p>2.Үр тарианы зориулалттай газар эзэмших эрх нь хөрөнгийн биржийн эрхлэх үйл ажиллагаанд хамаарахгүй, зориулалт бус хөрөнгө бөгөөд жил бүр тус газартай холбогдох төлбөр, хураамжийн зардал гаргаж байна</p>	1.Хөрөнгийг биет бус хөрөнгөөр ангилан бүртгэх 2.Холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэр гаргуулж зах зээлийн үнээр худалдан борлуулах	1	13,160.0									1	13,160.0
7	Монголын хөрөнгийн бирж ТӨХК	АХГ-2022/47/НА-СТА-ТӨА	Өмнөх онуудад газар эзэмших эрхэд 1.3 сая төгрөгийн элэгдэл байгуулж хуримтлуулан бүртгэсэн байна.	Газар эзэмших эрхэд байгуулсан хуримтлагдсан элэгдлийг бууруулан өмнөх үеийн үр дүн рүү залруулан бүртгэх	1	1,336.1									1	1,336.1
8	Монголын хөрөнгийн бирж ТӨХК	АХГ-2022/47/НА-СТА-ТӨА	Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 249 нэр төрлийн 9,488.2 сая төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т хүргүүлж шийдвэрлүүлээгүй байна.	Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийн талаар холбогдох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т хүргүүлж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах	1										1	
ДҮН					8	85,914.5	4	32,924.0	-	-	1	38,494.4	-	-	3	14,496.1



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 406/А0150053
АХГ-2022/47/ИА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд санхүүгийн тайлан дахь авлага, өглөгөөс 29 харилцагчийн 38,267,890 төгрөгийн авлага, 2 харилцагчийн 226,510 төгрөгийн өглөг, нийт 38 494,400 төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, нийт цэвэр авлагын 86.5 хувь нь нэг жилээс дээш жилийн насжилттай байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "...төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "... дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээ гарахаас нь өмнө хянан баталгаажуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8 "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/05 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлаг, өглөгийн дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөрөнгийн бирж ТӨХК-ийн Захирал Х.Алтай, нягтлан бодогч С.Алтаннамар нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АККАУНТ ТРАСТ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
П.НАРАНЦЭЦЭГ

9006109
901910396

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засагтын газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Газар-96.Docx

0010831176

